

**НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГЫН ТОХИРОЛЦОО**

Монгол Улсын эрх бүхий этгээд болон Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх бүхий этгээдүүд,

2006 он 5 сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр (цаашид "хэлэлцээр" гэх)-ийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Нэр томъёо

Энэхүү удирдлагын тохиролцоонд хэрэглэсэн нэр томъёо нь хэлэлцээрт хэрэглэсэн утгатай ижил байна.

2 дугаар зүйл

Харилцагч байгууллагууд

1. Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан харилцагч байгууллагууд нь:

(а) Монгол Улсын хувьд Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар;

(б) БНСУ-ын хувьд Үндэсний тэтгэвэрийн алба байна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан харилцагч байгууллагууд нь хэлэлцээр болон энэхүү удирдлагын тохиролцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай хамтарсан журам болон хэлбэрийг тохиролцоно.

3 дугаар зүйл

Даатгалд хамрагдсан тухай сертификат

1. Хэлэлцээрийн II хэсгийн аль ч заалтын дагуу хэлэлцэн тохирогч аль нэг талын хууль тогтоомжийг хэрэглэж болох нөхцөлд тухайн хэлэлцэн тохирогч талын харилцагч байгууллага нь ажилчны болон ажил олгогчийн хүсэлтийг үндэслэн сертификат олгох бөгөөд түүнд уг ажилчин нь тухайн улсын хууль тогтоомжид хамаарахыг, мөн сертификатын хүчинтэй байх хугацааг зааж өгнө. Энэхүү сертификат нь тухайн ажилчныг хэлэлцэн тохирогч нөгөө талын заавал хамрагдах хууль тогтоомжоос чөлөөлөгдөнө гэдгийг батална.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан сертификатыг олгож байгаа хэлэлцэн тохирогч талын харилцагч байгууллага нь сертификатуудын хуулбарыг ажилчин, ажил олгогч болон хэлэлцэн тохирогч нөгөө талын харилцагч байгууллагад тус тус хүргүүлнэ.

3. Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш БНСУ-ын Үйлдвэрлэлийн дадлага эзэмшүүлэх тогтолцоо эсхүл Хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрлийн тогтолцооны дагуу БНСУ-д хөдөлмөр эрхлэхээр очсон монгол ажилчны хувьд Монголын харилцагч байгууллага нь даатгалд хамрагдсан тухай сертификатыг ажилчинд нэг хувь, БНСУ-ын харилцагч байгууллагад нэг хувийг тус тус олгоно. Харин хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө БНСУ-ын Үйлдвэрлэлийн дадлага эзэмшүүлэх тогтолцоо эсхүл Хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрлийн тогтолцооны дагуу БНСУ-д очсон монгол ажилчдын хувьд холбогдох этгээдийн нэрсийн жагсаалтыг Солонгосын харилцагч байгууллага нь Монголын харилцагч байгууллагад илгээх бөгөөд дээр дурдсан нэрсийн жагсаалтыг үндэслэн Монголын харилцагч байгууллага нь эдгээр ажилчдад сертификат олгож эсхүл даатгалд хамрагдсан хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргаж солонгосын талын харилцагч байгууллагад илгээнэ.

4 дүгээр зүйл

Тоо бүртгэл солилцох

Хэлэлцэн тохирогч талуудын харилцагч байгууллагууд нь энэхүү удирдлагын тохиролцооны 3 дугаар зүйлийн дагуу олгогдсон сертификатуудын жилийн тоо бүртгэлийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харилцан солилцоно.

5 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

Энэхүү удирдлагын тохиролцоо нь хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс үйлчилж эхлэх бөгөөд хүчин төгөлдөр байх хугацаа нь ижил байна.

Энэхүү тохиролцоог Засаг даргаар хатгалар, 2006 оны 5-р сарын 8-ны өдөр (он сар өдөр) монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тохиролцоог тайлбарлахад санал зөрөх тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтлана.

Монгол Улсын
эрх бүхий этгээдийг төлөөлж



Бүгд Найрамдах Солонгос
Улсын эрх бүхий этгээдийг
төлөөлж

